



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/52

Хөхбүрд

Малын угаалгын ванн хийх ажлын гүйцэтгэгчийг  
сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний  
хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малын угаалгын ванн хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга: Д.Эрдэнэбулган (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд:Л.Алимаа (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

Ө.Ариунзаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Г.Мандаахүү (Хөндлөнгийн төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Э.Мөнх-Эрдэнэ (Сан хариуцсан нягтлан бодогч)

2.Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж, авилга, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллахыг үнэлгээний хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д даалгасугай.

ДАРГА  БЯМБАДОРЖ



642501013

D/2025/Засаг даргын захирамж А4.docx

